

2004 оны 10–р сарын 14–17–ны өдрүүдэд
Индиана мужийн Блумингтон хотын Индиана их сургууль дээр явагдсан
Монголын Нийгэмлэгийн жилийн хуралдаан дээр
Элчин сайд Памела Слуцын хэлсэн үг

Америк–Монголын харилцаа:
Хамтын үнэт зүйлс болон стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан
иж бүрэн түншлэл

Ноёд, хатагтай нараа!

Улаанбаатарт суугаа элчин сайдын хувьд Америк–Монголын харилцааны сүүлийн үеийн байдлын тухай ярихаар Монголын Нийгэмлэгийн урилгаар өнөөдөр би энд хүрэлцэн ирсэндээ баяртай байна. Би илтгэлээ "Америк–Монголын харилцаа: Хамтын үнэт зүйлс болон стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан иж бүрэн түншлэл" гэж нэрлэсэн юм. Энэ нэр манай хоёр орон болон ард түмнүүдийн харилцаа улам өргөжин гүнзгийрч буйг илэрхийлж байгаа гэдэгт би итгэж байна. Энэ цаг үе бол Ерөнхийлөгч Буш болон Америкийн ард түмнийг Монгол улсад төлөөлж суухад үнэхээрийн сонирхолтой цаг үе юм.

Өндөр түвшний айлчлалууд

Бидний ажил мэргэжлийн хувьд хоёр орны харилцааны ач холбогдлыг дүгнэхдээ айлчлал, ялангуяа өндөр түвшний хоёр талын айлчлалын тоо болон хэлэлцэгдэж буй асуудлуудын мөн чанарыг голчлон авч үздэг. Элчин сайдаар ажилласан эхний нэг жилийн дотор миний бие болон манай ажилтнууд АНУ–ын өндөр албаны хэд хэдэн хүнийг хүлээн авсны дотор 2004 онд Зэвсэгт хүчний штабуудын нэгдсэн хорооны дарга Генерал Ричард, хатагтай Майерсын хамт, мөн Төрийн департаментын орлогч дарга Ричард Армитейж нар Монголд айлчилсан нь 1998 оны 5–р сард хийгдсэн Төрийн нарийн бичгийн дарга Мадлен Олбрайтын айлчлалаас хойшхи хамгийн дээд хэмжээний айлчлалууд боллоо.

Нөгөө талаас Ерөнхийлөгч Бушийн урилгаар Ерөнхийлөгч Багабанди 2004 оны 7–р сард АНУ–д албан ёсны айлчлал хийсэн бөгөөд энэ нь Монгол улсын ерөнхийлөгч 12 жилийн дараа АНУ–д айлчилсан явдал болов. Нилээд хэдэн жил өнгөрсний эцэст АНУ–ын Сангийн яамны урилгаар Монгол улсын Санхүү, эдийн засгийн сайд энэ оны 4–р сард Вашингтон хотод айлчлал хийлээ. Мөн 10–р сарын 9–нд Монгол улсын Батлан хамгаалахын шинэ сайд Ирак дахь Олон үндэстний эвсэлд нэгдсэн бусад орнуудын батлан хамгаалах сайд нарын хамт АНУ–ын Батлан хамгаалахын нарийн бичгийн дарга Рамсфельдын зохион байгуулсан уулзалтанд оролцов.

АНУ–ын Танхим болон Сенатын зарим гишүүд Монгол улсад тусгайлан анхаарал хандуулсаар ирсэн хэдий ч сүүлийн жилүүдэд конгрессийн айлчлал ховор хийгдсэн байна. Монгол улсаас АНУ–д суугаа Элчин сайд Болд болон

миний бие энэ төрлийн солилцоог дахин сэргээх бодолтой байна. 7-р сард Ерөнхийлөгч Багабандийн айлчлалын үеэр Конгрессын гишүүн Ж.Питтс, Ж.Уилсон нар [АНУ-ын](#) Конгресст Монголыг дэмжих бүлэг байгуулснаа албан ёсоор тэмдэглэж хүлээн авалт хийсэн билээ. Энхүү бүлэг нь хоёр талын харилцааг бэхжүүлэн гүнзгийрүүлэхийн төлөө ажиллаж, бид 2005 онд Монголд айлчлах конгрессийн төлөөлөгчдийг хүлээн авна гэдэгт итгэж байна.

Харилцааны үзүүлэлтүүд

Ямар ч шалгуураар авч үзсэн АНУ нь Монгол улсын маш чухал түнш билээ. Зарим нэг тоо баримтыг авч үзье. 2003 онд

- АНУ нь Монгол улсын худалдааны гуравдахь том түнш (Хятад, Оросын дараа ордог) байсан бөгөөд худалдааны алдагдал хүлээсэн. Худалдааны нийт эргэлт нь 166 сая ам.доллар байснаас 143 сая нь Монголоос АНУ-д гаргасан экспорт байсны 90 хувь нь оёмол, сүлжмэл бүтээгдхүүн байсан байна.
- АНУ-аас Монголд 115 сая орчим ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн нь Хятад, Канадын дараа гуравдугаарт буюу нийт хөрөнгө оруулалтын 15 хувийг эзэлж байна.
- АНУ Монгол улсын гуравдагч том хандивлагч буюу Япон, Германы дараа ордог бөгөөд [АНУ-ын](#) ОУХА болон Хөгжлийн агентлагийн хөтөлбөрүүдээр дамжуулан жилд 16 сая орчим ам.долларын эдийн засгийн дэмжлэг үзүүлсэн байна.
- 2000 оноос хойш [НУБ-ын](#) жишигт хүрэхүйц олон улсын энхийг сахиулах чадавхийг хөгжүүлэх зорилгоор Монголын зэвсэгт хүчинд 2 сая гаруй ам.долларын тусламж үзүүлсэн. 2003 оны 8-р сараас Монгол улс Иракт 400 гаруй энхийг сахиулагч болон Афганистанд зөвлөхүүдийн 2 багийг илгээсэн байна.
- Мөн 2003 онд Америкт суралцагч Монгол оюутнуудын тоо өмнөх жилээс 29 хувиар нэмэгдэж 740 болсон гэдгийг тэмдэглэж хэлмээр байна.

Хоёр талын харилцааны гол асуудлууд

Дипломат харилцаа тогтоосноос хойшхи 16 жилийн дотор Америк-Монголын харилцаа улам бүр өргөжин гүнзгийрсээр байна. Монгол улс захиргаадалтын коммунист засаглалаас ардчилсан, чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжих 10 жил үргэлжилсэн тайван бөгөөд бүх салбарт нэгэн зэрэг явагдсан шилжилтийн үйл явц нь Ази тивийн амжилтын түүхэнд зүй ёсоор бичигддэг. Үнэндээ Монголын ард түмэн асар их амжилт олсон. Гэхдээ эдгээр ололт амжилтаа бататгаж, бүх монголчуудын аж амьдралын түвшинг дээшлүүлэхийн тулд хийх зүйл зөндөө байна.

Өнөөдөр Монгол улс бол АНУ-д үнэлэгддэг найз нөхөр нь бөгөөд түнш нь юм. Монгол улс хөрш орнуудтайгаа найрсаг харилцаа хөгжүүлж, бүс нутгийн болон олон улсын эдийн засаг, улс төр, аюулгүй байдлын чуулга уулзалтуудад идэвхтэй оролцож, ардчилсан, хараат бус, аюулгүй байдлаа бүрэн хангасан,

цэцэглэн хөгжиж буй улс болж, улмаар тийм байдлаа хадгалан байх нь [АНУ-ын](#) үндэсний ашиг сонирхолд нийцэж байгаа юм. Терроризмын эсрэг дэлхий нийтийн тэмцэл болоод Ази, ялангуяа Зүүн Хойд Азийн энх тайван, тогтвортой байдлыг хангахад Монгол улс дэмжлэг үзүүлсээр байна.

7-р сарын [15-нд](#) манай хоёр орны ерөнхийлөгч нар Вашингтонд уулзах үеэр хамтарсан мэдэгдэл хийсэн бөгөөд энэ мэдэгдэлдээ "ардчилсан хоёр орны хооронд хамтын үнэт зүйлс болон стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан хамтын ажиллагаа, иж бүрэн түншлэлийн шинэ эрин үеийг зарлан тунхагласан" билээ.

"Хамтын үнэт зүйлс" гэдгээр бид ардчилсан засаглал, хувийн хэвшил давамгайлсан чөлөөт эдийн засгийн төлөө тууштай байхыг хэлж байгаа юм. Монгол улс бол ардчилсан орнуудын томоохон хамтын нийгэмлэгийн хүндтэй гишүүн бөгөөд ижил төстэй замаар замнаж буй Төв болон Зүүн Европын бусад орнуудын хувьд үлгэр жишээ болж байгаа юм.

"Стратегийн нийтлэг эрх ашиг" гэдэгт бид олон улсын терроризмтай тэмцэх, Зүүн хойд Азид энх тайван, тогтвортой байдлыг тогтоох, үүнд Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид байлгахын төлөө тууштай байхыг хамаатуулж ойлгож байна. Ялангуяа Ерөнхийлөгч Буш Афганистан, Иракийг тогтворжуулах, сэргээн босгох үйл ажиллагаа, түүнчлэн Ирак дахь олон улсын энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд оролцох талаар Монгол улс шийдвэр төгс байгааг өндрөөр үнэлсэн билээ.

Терроризмын эсрэг дэлхий нийтийн тэмцэл

Терроризмтай тэмцэх, Афганистан, Иракийг тогтворжуулах, сэргээн босгох үйл ажиллагаанд оролцох талаар гаргаж буй Монгол улсын хүчин чармайлтыг АНУ талархан хүлээн авч, өндрөөр үнэлж байна. Монгол улс Эвсэлд нэгдсэн эхний орнуудын нэг байсан бөгөөд 3 удаагийн ээлжээр 400 гаруй энхийг сахиулагч нараа Ирак руу илгээгээд байна. Одоо Иракт Монголын 120 энхийг сахиулагч цэрэг, Афганистанд арав гаруй зөвлөх ажиллаж байна. Иракийн өмнөд хэсэгт Польшийн командлалд байгаа тэр 120 цэрэг бол удаан хугацааны хөтөлбөрийн 3 дахь ээлж нь юм. Эхний 2 ээлжийн цэргүүд 2, [8-р](#) саруудад эх орондоо эргэж ирэхэд нь тэднийг баатрын ёсоор угтаж авсан билээ.

Энэ нь орчин үед монгол цэргүүд гадаадад үүрэг гүйцэтгэсэн анхны тохиолдол болохыг дурдах нь зүйтэй байх. Мэдээж хэрэг, цэргүүд болон тэдний гэр бүлийнхэнд тодорхой хэмжээний айдас түгшүүр байсан нь ойлгомжтой. 2-р сарын [16-ны](#) өдөр эхний ээлжийн бие бүрэлдхүүн 6 сарын үүргээ гүйцэтгэж дуусаад эх орондоо эргэж ирэхэд нь миний бие Улаанбаатарын нисэх онгоцны буудал дээр байсан юм. Отгон хүүгээ угтаж авч байсан нэг эмэгтэй над руу ирээд хүү нь эсэн мэнд эргэж ирсэнд ямар их баярлаж буйгаа, бас хичнээн их бахархаж буйгаа хэлж билээ. Бас нэг цэрэг анх удаа хүүгээ тэвэрч байлаа.

Түүнээс хэдхэн хоногийн дараа буюу 2-р сарын дунд үеэр Иракт [2-р](#) ээлжээр очоод 3 долоо хоног ч болоогүй шахам байсан монгол цэргүүдийн нэг Ал

Хиллах дахь Эвслийн бааз руу дайран орж бөмбөг дэлбэлэх оролдлого хийсэн амиа золиослогчийг зогсоож чадсан юм. Тэр цэргийг Польш, Америкийн засгийн газраас шагнасан бөгөөд 8-р сард эх орондоо эргэж ирэхэд нь Монгол улсад анх удаа "Энх тайвны төлөө" медалиар түүнийг болон нөхдийг нь шагнасан билээ.

Олон улсын жишигт хүрэхүйц энхийг сахиулах чадавхийг хөгжүүлэн бэхжүүлэх гэсэн Монгол улсын зорилгыг 2000 оноос хойш хэрэгжиж буй цэргийн тусламжийн хөтөлбөрүүдээрээ АНУ дэмжсээр ирсэн. Бэрхшээлтэй байгаа дэлхийн бусад өнцөг буланд олон улсын үүрэг гүйцэтгэх зорилгоор Монголын энхийг сахиулагч хүчнийг сургах, зэвсэг техникээр хангах тусламжаа үргэлжлүүлэх бодолтой байна. Монгол улс олон улсын хамтын нийгэмлэгт хариуцлагатай үүрэг гүйцэтгэх сонирхолтой байгаа нь бидэнд ч мөн ашигтай бөгөөд энэхүү чадавхийг бүрдүүлэхэд нь тусламж үзүүлж байгаадаа бид бахархалтай байна.

Ардчилал

Монгол улс Ази тивийн бусад орнуудын хувьд үлгэр жишээ болон дурьдагдах нь цөөнгүй. Арав хүрэхгүй жилийн дотор захиргаадлаас засаглалын ардчилсан хэлбэрт шилжих үйл явцыг тайван замаар хийж чадсан энэ орны туршлага гайхамшигтай бөгөөд үнэндээ дэлхийд хосгүй юм. Монголд парламентын болон ерөнхийлөгчийн сонгууль хэд хэдэн удаа явагдсан бөгөөд засгийн эрх нэг намаас нөгөөд тайван замаар гурван удаа шилжсэн билээ.

Монгол улсад ардчиллыг бэхжүүлэх үйл явц дуусаагүй байна. Ил тод байдал, хариуцлагыг улам нэмэгдүүлэх гэсэн сонгогчдын шаардлагад нийцүүлэн сонгуулийн шинэчлэл хийх хэрэгтэй байгааг өнгөрсөн 6 сарын 27-нд болсон УИХ-ын сонгууль тод харууллаа. Нийт сонгогчдын 76 хувь нь оролцсон уг сонгуулийн үр дүн нэр дэвшигчид болон мэргэжилтнүүдийг гайхашралд оруулсан бол улс төрийн голлох хоёр хүчний тэнцвэртэй байдлын төлөө саналаа өгсөн сонгогчид үүнд гайхсангүй. Санал хураалтын дүнд МАХН, Эх орон-Ардчилал эвсэл (Ардчилсан нам, МАШСН, ИЗН)-д ихэнх суудал хуваагдаж, бие даан нэр дэвшигчид 3 суудал, БНН 1 суудал авсан билээ. МАХН-ын суудлын тоо 72-оос 36 болж, Эх орон-Ардчилал эвслийнх 4-өөс 34 болсон бөгөөд 2 суудлын асуудал маргаантай байна.

Улс төрийн голлох 2 хүчний аль аль нь сонгуулийн үйл явц будилаантай болсон, сонгуулийн кампанит ажил болон санал хураалтын үед улс төрийн хоёр хүчин, сонгуулийн тойргийн хороодын гишүүдийн зүгээс олон тооны зөрчил гаргасан гэж үзэж байгаа юм. Хэд хэдэн тойрогт саналын хуудсыг дахин тоолсон. МАХН хоёр тойрогт дахин сонгууль явуулах хүсэлтийг албан ёсоор гаргасан бөгөөд Сонгуулийн хуулинд зааснаар дахин сонгууль явуулахыг зөвшөөрдөг ажээ. Монголын шүүх 7-р сарын 18-нд 2-р тойрогт явуулсан дахин сонгуулийг хүчингүй болгож, суудлыг Эх орон-Ардчилал эвслээс нэр дэвшигчид өгөхөөр шийдвэрлэсэн. Одоо энэ 2 тойргийн асуудал хуулийн дагуу давж заалдах шатны шүүхэд байна.

Сонгуулийн үйл явцад нийтээрээ сэтгэл дундуур байсан хэдий ч хүч хэрэглэсэн тохиолдол гараагүй бөгөөд маргаантай асуудлыг хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлэхээр өгсөн. Хамгийн чухал нь улс төрийн хоёр хүчин сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрч, Монгол улсад ардчилал өрнөсөн 14 жилийн түүхэнд анх удаа 50х50 хувиар эвслийн засгийн газар байгуулахаар тохиролцож чадсан явдал юм. Олонхийн суудал авсан нам байхгүй болохоор намууд хоорондоо болон нам дотроо удаан хугацааны хэлэлцээр хийсний эцэст Их хурал, Засгийн газрын гол гол албан тушаалыг голлох хоёр улс төрийн хүчин хуваан авсан Их эвслийн засгийн газрыг байгууллаа. **УИХ-ын** дарга (эрэмбээрээ Ерөнхийлөгчийн дараа **2-рт** орно) болон Ерөнхий сайд (3 дахь хүн), мөн 13 яамдын сайд, дэд сайдууд нь өөр өөр намын гишүүд байна. Улс төрийн хүчнүүдийн тэнцвэртэй харьцааг хадгалах үүднээс хэд хэдэн байнгын хороод, яамд болон шадар сайдын орон тоог шинээр бий болгосон байна. Хүчний энэхүү тэнцвэрийг цаашид хадгалах зорилгоор **УИХ-ын** дарга болон Ерөнхий сайд (шадар сайд)-ын албан тушаалд 2 жилийн дараа нөгөө намаас нь томилогдоно.

Намайг өнгөрсөн Мягмар гаригт Улаанбаатараас гарах үед эвслийн шинэ Засгийн газар ирэх 4 жилд баримтлах мөрийн хөтөлбөр дээрээ ид ажиллаж байлаа. Ингэхдээ аль нэг улс төрийн хүчин дангаараа засгийн эрх барьж байх үед шийдвэрлэхийг зориогүй, эсвэл шийдвэрлэх боломжгүй, хэцүү асуудлуудыг тэргүүн ээлжинд авч үзэх, шийдвэрлэх талаар зөвшилцөлд хүрсэн билээ. Үүнд:

- Сонгуулийн хууль журмын шинэчлэл (сонгуулийн үйл явцыг илүү тэнцвэртэй бөгөөд ил тод болгож, хуулийн цоорхойг чангатгах)
- Хэвлэл мэдээллийн шинэчлэл (төрийн мэдэлд байдаг Монгол телевиз, радиог олон нийтийн өргөн нэвтрүүлгийн компани буюу олон нийтийн өргөн нэвтрүүлгийн систем болгох)
- Төрийн албаны шинэчлэл (мэргэжил, чадварт суурилсан системийг нэвтрүүлж, хүнд суртлыг багасган, үйл ажиллагааг нь илүү нээлттэй, ил тод болгох)
- Татварын шинэчлэл (татварыг хэмжээ, дарамтыг бууруулан, татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлэх)

Хамгийн чухал нь шинэ Засгийн газар "авилгалын эсрэг дайн" зарласан бөгөөд 2005 онд багтаан Авилгалын тухай **НҮБ-ын** конвенцид нэгдэн орохоо тууштай мэдэгдэж байна. Сүүлийн үед үндэсний болон олон улсын хэмжээнд хийгдсэн судалгаануудаар Монголд улам бүр газар авсаар байгаа авилгал хээл хахуультай хэд хэдэн фронтоор тэмцэх бөгөөд тухайлбал, Авилгалын эсрэг чангахан хуультай болж, хэрэгжүүлж эхэлнэ. Мөн эрх зүй, төрийн үйлчилгээг стандартын шинэ шатанд гаргаж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

Шинэ Засгийн газар бас "ядууралд дайн зарласан" бөгөөд хүүхэд хамгаалалд чиглэсэн хөтөлбөрүүд, тухайлбал сургуулийн хүүхдэд зориулсан хоол, сурах бичгийн ваучер, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга замыг хайж байна.

Мэдээж энэ Засгийн газрын өмнө маш олон бэрхшээл байгаа. Гэхдээ сайн санаа, олон түмэн сонгогчдын итгэл найдварыг биелүүлэх эрмэлзлийн үүднээс эдгээр чухал зорилтуудыг шийдвэрлэхийн тулд бие биетэйгээ сөргөлдөх бус харин хамтран ажиллах нь ашигтайг хоёр улс төрийн хүчин олж харна гэдэгт би итгэлтэй байна.

Чөлөөт зах зээлийн эдийн засаг

1990–ээд оны эхээр Монголын ард түмэн хуучин коммунист загварын засаглалыг халж оронд нь чөлөөт зах зээлийн эдийн засгийг сонгосон билээ. Энэ зам шулуун дардан байгаагүй. Газар зүйн алслагдмал байрлал, хүнд хэцүү цаг агаарын нөхцөл, хүн амын сийрэг суурьшил зэрэг нь маш олон бэрхшээлийг бий болгодог. 1990–ээд оны эхээр хуучин ЗХУ Монголоос гарахдаа эдийн засгийн тусламж дэмжлэг, мэргэжилтэй боловсон хүчин, Төв Европын зах зээлд гарах гарц бүгдийг нь нэг мөсөн аваад гарсан. Монгол даяар үйлдвэрүүд хаагдаж, хүмүүс буцаад мал аж ахуй эрхлэхээс өөр замгүй болсон. Хүн амын бараг 40 хувь нь мал аж ахуй эрхэлдэг Монголчуудын хувьд энэ нь дөнгөж амь зуух төдий хэмжээнд байсаар байна.

2000, 2001 оны бэрх өвлийн зуданд хэдэн мянган толгой мал хорогдсон. Маш харамсалтай боловч олон хүн энэ бол зайлшгүй болох зүйл байсан бөгөөд дахин давтагдаж ч болзошгүй гэж хэлдэг. Хэтэрхий бага бэлчээр дээр хэт олон хүн хэт олон мал өсгөх гэж оролдсоноос Монголын өмнөд, баруун болон төв хэсгээр бэлчээрийн даац хэтрэх, цөлжих, экологийн тэнцвэр алдагдах зэрэг нь дэлхий даяар дулаарах хандлагатай хослон ноцтой байдалд хүрч, одоо болон ирээдүй үеийн амин зуулгад муугаар нөлөөлөхүйц болоод байна.

Макро–эдийн засгийн тогтвортой байдал: 2003 онд Монгол улсын эдийн засаг 3.9 хувиар өссөн байна. 2004 онд өсөлтийн хувийг 6, зарим эх сурвалжууд бараг 8 байхаар таамаглаж байна. Эдийн засгийн өсөлтийн ихэнх хувь нь уул уурхайн салбар, мөн дэлхийн зах зээл дээр алт, зэсийн үнэ дунджаас дээгүүр байснаас үүдэлтэй.

Монголын болон Дэлхийн банкны тоо баримтаас харахад 2003 онд ДНБ 1.4 тэрбум ам.долларт хүрсэн байна. Харин албан бус "сүүдрийн эдийн засгийн" тооцоогоор бол бодит ДНБ 2 тэрбумаас багагүй гэж гарсан байна. (ТТГ–ын Дэлхийн Баримт номонд 5 тэрбум гэсэн тоог гаргахдаа худалдан авах чадварыг харьцуулах аргачлалыг ашиглажээ. Мөн энэ аргачлалаар Монгол улсын нэг хүнд ноогдох ҮНБ 1,900 ам. доллар байсан). Улаанбаатар хотод цэцэглэж байгаа барилгын болон бусад бизнесийн үйл ажиллагааг хөдөлгөгч хөрөнгийн гол эх үүсвэр нь гадаадад ажиллаж байгаа монголчуудын гуйвуулсан буюу гадаадын банкинд монголчуудын хадгалсан мөнгө байдаг. Энэ хөрөнгийн ихэнх хэсэг нь татварын байцаагч, банкны ажилтны гараар дамждаггүй учир баталгаатай тоо баримт байхгүй байна. Санхүүгийн эдгээр хэлцлийг барьж авна гэдэг Засгийн газрын хувьд үнэхээр төвөгтэй асуудал. Татвараас зайлсхийх оролдлогыг багасгах зорилготой татварын шинэчлэлийн асуудал шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт чухал байр суурь эзэлж байна.

Монгол улсын гадаад ба дотоод өр сонирхол татаж байна. 2003 оны эцсээр Оросод 250 сая ам.долларын өрийг төлсний дараа Монголын гадаад өр ДНБ-ний 110 хувьтай тэнцэж байсан бөгөөд өрийн ихэнх нь хөнгөлөлттэй нөхцөлтэй. Гэхдээ 2003 оны эцэст Оросын өрийг төлөхийн тулд засгийн газар богино хугацааны зээл авсан нь өрийн нийт дарамтанд нэрмээс болсон байна.

МАХН засгийн эрх барьж байсан сүүлийн саруудад улс төрийн зорилгоор хийгдсэн зарим зардал (төрийн албан хаагчдын цалин, тэтгэврийн нэмэлт) нэмэгдсэний улмаас 2004 оны төсвийн алдагдал ОУВС ба бусад хандивлагчдын хүлээж байснаас их боллоо. Шинэ Засгийн газрын нийгмийн хөтөлбөрүүд буюу шинээр төрсөн хүүхэд бүрт 100,000 төгрөг, шинээр гэр бүл бологсдод 500,000 төгрөг өгөх [МАХН-ын](#) амлалт, мөн хүүхэд бүрт сар бүр 10,000 төгрөг өгөх [Эх орон-Ардчилал](#) эвслийн амлалт нь "төсвийг сүйрүүлэх" аюултай. ОУВС сан, АНУ болон бусад хандивлагчид мөнгөнийн ханш унагаах ийм зардлын эсрэг байгаа, мөн эдгээр амлалтыг хэрэгжүүлэхдээ зорилго чиглэлтэй, дэмжиж болохуйц арга замыг олж тодорхойлох нь зүйтэйг Засгийн газарт сануулсан билээ .

Гадаадын зээл тусламж: Сүүлийн 10 жилийн турш Монгол улс зээл, буцалтгүй тусламжийн хэлбэрээр ихээхэн хэмжээний эдийн засгийн тусламж авсан. Эхний үед энэхүү тусламж нь Орос улс Монголд үзүүлэх дэмжлэгээ гэнэт зогсоосны улмаас үүссэн "хүмүүнлэгийн хямралыг" гэтлэн давахад зориулагдаж байв. Харин [1990-ээд](#) оны дунд үеэс иймэрхүү тусламж дэмжлэг нь Монгол улсыг хөгжүүлж, цаашдаа гадны зээл тусламжаас хамааралгүй болгох зорилго бүхий байгууллага, үйл ажиллагааг бий болгоход илүү чиглэгдэж байна.

[1991-2001](#) онуудад зээл тусламжийн хэмжээ жилд дунджаар 216 сая ам.доллар байснаас 214 сая нь бодитой олгогдож байв. [2002-2003](#) онд амалсан тусламжийн хэмжээ жилд 335 сая орчим ам.доллар байв. Бодоод үзвэл 10 жилийн турш нэг хүнд жилд 845 орчим ам.доллар буюу Монгол улс нэг хүнд ноогдох тусламжийн хэмжээгээрээ дэлхийд нэгдүгээрт биш юмаа гэхэд нилээд дээгүүрт орно гэдгийг харж болно.

Өнгөрсөн оны [11-р](#) сард Токиод болсон Хандивлагчдын уулзалт дээр Монголын гол хандивлагчид болох Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон Япон, Герман, АНУ зэрэг улсууд Монгол улс төлөвлөлт, зохицуулалт илүү их шаардагдах эдийн засгийн хөгжлийн шинэ үе шатанд орлоо гэж дүгнэсэн. Монгол улс нэг хүнд ноогдох гадаад зээл тусламжийн хэмжээгээрээ дэлхийд дээгүүр байранд байгаа хэдий ч тусламжийн өгөөжийн хувьд "хамгийн үр дүн багатай" орнуудын тоонд орж байгаа гэдэг дээр Токиод болсон яриа хэлэлцээрүүд анхаарлаа хандуулсан. Монгол улс бодитой бөгөөд тогтвортой хөгжлийн замд хараахан ороогүй, хөгжиж буй ертөнцийн хамгийн ядуу орнуудын тоонд байсаар байна.

[АНУ-ын](#) эдийн засгийн тусламж: АНУ нь 1991 оноос хойш ОУХА болон Хөгжлийн агентлагийн хөтөлбөрүүдээрээ дамжуулан эхлээд эрчим хүчний

хямралыг даван туулахад нь, одоо хувийн хэвшил давамгайлсан эдийн засгийн өсөлтийг хангахад нь Монголд тусламж үзүүлж байна. Өнгөрсөн 13 жилийн хугацаанд [АНУ-ын](#) Засгийн газраас 150 сая орчим ам.долларыг буцалтгүй тусламж болон хөдөө аж ахуйн бүтээгдхүүнийг дэмжих сан хэлбэрээр өгсөн байна. 1991 онд эхэлсэн [ОУХА-гийн](#) удирдлаган доор хэрэгжиж буй манай албан ёсны тусламжийн хөтөлбөр нь Монгол улсыг цаашид гадны зээл тусламжаас хамааралгүй болгоход туслах зорилгоор хувийн хэвшил давамгайлсан, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлж, ардчилал, хууль журам, сайн засаглалыг бэхжүүлэх харилцан уялдаатай 2 зорилт дээр төвлөрдөг юм. Бидний үзэж байгаагаар, сайн засаглал ба хүчтэй хувийн хэвшил 2 нь Монгол улс тогтвортой хөгжил, цэцэглэлтийн замыг олоход гол хүчин зүйлс болно. Хаана сайн засаглал, эдийн засгийн оновчтой бодлого байна, тэнд гадаадын тусламжийн 1 доллар хувийн хөрөнгө оруулалтын 2 долларыг татах боломжтой гэдэг нь судалгаагаар харагддаг.

Дараагийн 5 жилд манай тусламжийн стратеги ямар байх талаар 2003 оны 9-р сард нийтэд мэдээлсэн билээ. Тусгай зорилтот хөтөлбөрүүд нь макро эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, хувийн бизнес ба хөрөнгө оруулалт, улсын өмчит аж ахуйн нэгжүүдийн хувьчлал, эрх зүйн шинэтгэл, улс төрийн намууд болон парламентын шинэчлэл, эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бизнесийг хөгжүүлэх, Монголын хөдөө орон нутаг болон хот орчмын иргэдэд илүү өргөн боломж олгох зэрэгт чиглэгдэнэ.

Үр дүн: 1990 онд тэгээс эхэлж байсан бол өнөөдөр эдийн засгийн 75 гаруй хувь нь хувийн хэвшлийнхний гарт байна. [ОУХА-ийн](#) тусламжтай хийгдсэн Худалдаа, хөгжийн банк (ХХБ) болон ХААН банкны хувьчлал Монгол улсын төсөвт 20 орчим сая ам.долларын орлого оруулж, ойрын хэдэн жилийн дотор нэмж 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт оруулах амлалтыг авчирсан.

Монголд байгаа [ОУХА-ийн](#) төлөөлөгчийн газар нь дэлхийн бусад орнуудад байгаа [ОУХА-ийн](#) хөтөлбөрүүдтэй харьцуулахад хамгийн бага зардлаар өндөр бүтээмжтэй ажиллаж байгаа газар юм. Байнгын орон тооны нэг америк ажилтнаас гадна гэрээгээр ажилладаг нэг америк, маш чадварлаг 6 монгол ажилтнаас бүрдсэн энэ хөтөлбөрийн баг дэлхийн бусад орнуудад буй хөтөлбөрүүдийн дунд үлгэр жишээ болон дурьдагдах нь элбэг.

Монголд хандивлагч хоёр талт болон олон талт донорууд дотроос [АНУ-ын](#) хандив тусламж шууд засгийн газарт нь очдоггүйгээрээ нилээд өвөрмөц байж магадгүй гэдгийг би цохон тэмдэглэмээр байна.. Үүний оронд бид хандив тусламжаа Chemonics, Mercy Corps, IRI, CHF зэрэг олон улсын нэр хүндтэй, туршлагатай [ТТБ-уудаар](#) дамжуулан олгодог бөгөөд эдгээр байгууллагууд хөтөлбөрүүдийг удирдах Монгол ажилтнуудыг авч, сурган ажиллуулдаг юм. Энэ арга барил нь хариуцлага, гүйцэтгэлд суурилсан үр дүн, тогтвортой байдлыг хангана гэж бид үздэг.

МСС: 2004 оны 5-р сард Монгол улс Мянгань Сорилтын Сан хэмээх тусламжийн шинэ хөтөлбөрөөс тусламж авах болзлыг хангасан эхний 16 орны тоонд багтсан гэдгийг зарласан. МСС нь энэхүү тусламждаа нилээд шинэлэг

байдлаар хандаж байгаа бөгөөд "шударга хууль ёсыг баримталж, хүмүүстээ хөрөнгө оруулалт хийн эдийн засгийн эрх чөлөөг дэмжих" бодлогыг тууштай баримталсаар байгаа буурай ба хөгжиж буй орнуудыг урамшуулан дэмжих юм. Монгол улс тусламж авах эхний 16 орны тоонд багтсан нь зөвхөн "нэн ядуу" (нэг хүнд ноогдох жилийн орлого нь 1415 ам.доллараас бага) гэсэн гол шалгуурыг хангаад зогсохгүй нэр дэвшигдсэн бусад 62 оронтой харьцуулахад улс төр, эдийн засгийн 16 шалгуур үзүүлэлтээр сайн дүн үзүүлсэнтэй холбоотой.

Одоо Монгол улс Мянганы Сорилтын Корпорацид өргөн барьж хэлэлцүүлэх төслийг боловсруулах шатандаа явж байна. Бэрхшээл нь гэвэл юуг нэн тэргүүнд тавихаа тодорхойлж, 3–5 жилийн дараа хэмжиж болохуйц өсөлт гарахаар салбарыг сонгож авах явдал байна. Мянганы Сорилтын Сан бол эдийн засгийн тогтвортой өсөлтийг эхлүүлэх зорилгоор хамгийн ирээдүйтэй салбарт нэг удаагийн, томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийх тусламжийн шинэ хэлбэр юм.

Хэрэв Мянганы Сорилтын Корпораци Монголын төслийг сайн болсон гэж үзвэл СОМРАСТ гэрээг байгуулах зорилгоор хэлэлцээр хийнэ. Мөнгөний хэмжээ нь тухайн төслийн мөн чанар, бусад орнуудын төсөлтэй өрсөлдөх чадвар, мөн хүн амын тоо, гадаад орнуудаас авдаг бусад тусламжийн хэмжээ зэргээс хамаарна. Энэ хөтөлбөрийн талаар нэмэлт мэдээлэл, тухайлбал улс орнуудыг ямар шалгуур үзүүлэлтүүд, аргачлалаар дүгнэж байгаа, мөн төсөл бичих удирдамж зэргийг мэдэж авахыг хүсвэл www.mca.gov гэсэн сайтад хандана уу.

Худалдаа, хөрөнгө оруулалт

Манай эдийн засгийн тусламжийн хөтөлбөрүүдийн талаар би нилээд их ярилаа. Үүнтэй адилхан ач холбогдол бүхий нэг баримт бол АНУ нь Монголын хувьд маш чухал хөрөнгө оруулагч бөгөөд худалдааны түнш билээ. 2003 оны эцэс гэхэд АНУ Монгол улсын худалдааны гуравдахь (Хятад, Оросын дараа орох) том түнш бөгөөд хөрөнгө оруулагч (Хятад, Канадын дараа ордог) байлаа.

Худалдаа: 2003 онд худалдааны эргэлт 166 сая ам.доллар байснаас 143 сая нь Монголоос Америк руу экспортлосон бараа бүтээгдхүүн, 23 сая нь [АНУ-аас](#) Монголд нийлүүлсэн голдуу хүнд машин механизм, машин, мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, үйлчилгээ зэрэгт ноогдож байна. Нийт эргэлтийн хэмжээ харьцангуй бага ч гэсэн [АНУ-ын](#) зах зээл Монголын хувьд нээлттэй байсаар байгаа нь чухал юм. Гэхдээ АНУ-д гаргаж байгаа Монголын экспортын бүтээгдхүүний ихэнх хувийг оёмол, сүлжмэл бүтээгдхүүн эзэлж байгаа бөгөөд 2005 онд ДХБ-ын Малтифайбер гэрээний хугацаа дуусч, оёмол сүлжмэл бүтээгдхүүний квот байхгүй болохоор Монголын оёмол сүлжмэл бүтээгдхүүний экспорт нь Хятад болон бусад орны илүү өндөр бүтээмжтэй үйлдвэрлэгчдийн ширүүн өрсөлдөөнтэй тулгарах болоод байна. 2004 оны эхний хагас жилийн тоо баримтаас харахад АНУ-д гаргасан экспортын хэмжээ бараг тал шахам хувиар (143 саяас 72 сая хүртэл) буурсан байна. Бид

хоёрдогч зах зээл, илүү өрсөлдөөнтэй үйл ажиллагааг хөгжүүлэх талаар монголын үйлдвэрлэгчидтэй ажиллаж байна. Жишээлбэл, Монгол улсын Засгийн газрын зүгээс дотоодын үйлдвэрлэгч нартаа татварын илүү хөнгөлөлттэй нөхцөл олгох боломж байгаа юм. АНУ-ын Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн дагуу ялангуяа оёмол, сүлжмэл бүтээгдхүүн нь хөнгөлөлттэй нөхцөлд хамаардаггүй учир АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газар өөр бусад нилээд олон тооны бүтээгдхүүнд тарифын хөнгөлөлт үзүүлэх тухай Монгол улсын өргөдлийг судалж байна.

Хөрөнгө оруулалт: Өнөөдөр Монголд оруулж байгаа Америкийн хөрөнгө оруулалт нийт хөрөнгө оруулалтын 15 орчим хувийг эзэлж байна. Хойд Америк-Монголын бизнесийн зөвлөлийн гишүүн Америкийн компаниуд голчлон санхүү, уул уурхай, боловсрол, оёмол эдлэл үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байна. ОПИС буюу Гадаадын Хувийн Хөрөнгө Оруулалтын Корпораци гэж холбооны байгууллага Монголыг ихэд сонирхож эхэлсэн бөгөөд 2004 оны 7-р сард Монголд байгаа Америкийн хөрөнгө оруулагч нарт зориулан 50 сая ам.долларын зээлийн шугам нээснээ зарласан билээ. Өнгөрсөн жил аялал жуулчлал, уул уурхай, боловсрол гэсэн 3 чиглэлээр хийгдсэн Америкийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн байна. Энэ байгууллага бусад хөрөнгө оруулагч нартай холбоо тогтоох сонирхолтой байгаа бөгөөд сонирхсон хүмүүс надаас мэдээллийг нь авч болно.

Монгол улсад үзүүлэх тусламжийг багасгаж харин гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт, мөн хэрэв эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах чадвартай гэж үзвэл худалдааг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж боддог олон хүнтэй би санал нэг байдаг. Хувийн хэвшил давамгайлсан, нээлттэй, чөлөөт зах зээлийн эдийн засгийн өсөлт нь шинээр ажлын байр бий болгож, илүү ашиг орлого авчирна. Зах зээл болоод зах зээлийн институцуудыг дэмжиж бэхжүүлэхэд чиглэсэн төр засгийн бодлого Монголчуудын урам зоригийг бадрааж, аж ахуй эрхлэх сэтгэлгээнд нь түлхэц болно.

Үүнд хүрэхийн тулд Монгол улс хэд хэдэн "саадыг" давах хэрэгтэй болно. Монгол улс "аварга том" эдийн засагтай улсуудаар хүрээлэгдсэн байдаг. Олон улсын хөрөнгө оруулалтыг татахын тулд бизнесийг тууштай дэмжсэн бодлого явуулдаг гэдгээ харуулах хэрэгтэй болно. Авилгал хээл хахуулийг арилгах, хүнд суртлын механизмыг халах, хөрөнгө оруулалтыг дэмжсэн татварын шинэтгэл хийх, хөрөнгө оруулалтыг дээд зэргийн үр ашигтай байлгахыг дэмжсэн санхүүгийн хүчирхэг системийг бий болгох, хөрөнгө оруулалтыг дэмжих эрх зүйн болоод зохицуулалтын бодлогоор хангах зэргээр бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй байна.

Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр: Элчин сайдаар ажиллах хугацаандаа миний өмнөө тавьсан нэг зорилго бол Америкийн хөрөнгө оруулалт, хоёр талын худалдааг нэмэгдүүлэх явдал юм. Монголын талаас Чөлөөт Худалдааны Хэлэлцээр байгуулах хүсэлт тавьсан юм. Хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтын түвшин одоохондоо бага байгаагаас шалтгаалан Чөлөөт Худалдааны Хэлэлцээр байгуулах арай эрт байгаа хэдий ч

[АНУ-ын](#) Худалдааны төлөөлөгчийн газар болон Монгол улсын Худалдаа, үйлдвэрийн яамны төлөөлөгчид хэлэлцээр хийж, 2004 оны 7 сарын 16-нд Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурсан юм. Энэ хэлэлцээрийн Хамтарсан зөвлөлийн анхны хоёр талын зөвлөлдөх, ажлын уулзалт энэ оны эцсээр Улаанбаатар хотод болно. Энэ нь засгийн газар, хувийн хэвшлийн хамтарсан хүчин чармайлт юм гэдгийг би цохон тэмдэглэмээр байна. Хамтарсан зөвлөлийн хуралдаанаар Америкийн талаас хэлэлцүүлэх асуудлыг боловсруулах талаар Америкийн хувийн хэвшлийнхэн [АНУ-ын](#) Худалдааны төлөөлөгчийн газартай зөвлөлдөх үйл явц одоо үргэлжилж байна.

Худалдаа хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр гэдэг нь [АНУ-ын](#) бусад оронтой хийх худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэхэд баримталдаг зөвлөх механизм юм. Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрийг олон улсын худалдаа, хөрөнгө оруулалалтанд эдийн засгаа нээлттэй болгох талаар эхний алхмуудыг хийж байгаа улс орнуудтай хийдэг. Энэ хэлэлцээрийн дагуу ямар нэг үүрэг хүлээхгүй ч худалдааны онцлог асуудлуудыг гарган тавьж, худалдааны түншүүддээ туршлага хуримтлуулах, институциуд болон хууль тогтоомжийг бий болгож, дэлхийн эдийн засагт нэгдэн ороход нь туслах зэргээр шууд үр дүнг нь үзэх боломжтой.

Мөн түүнчлэн дараа жил бид Давхар татварын тухай гэрээг байгуулахаар тохиролцсон байгаа. Монголын талаас авч хэрэгжүүлэх шинэчлэлийн бодлогууд, Америкийн талаас хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого зэрэг энэ бүх арга хэмжээ, шинэ гэрээ хэлэлцээрүүд нь хамтын зорилгодоо хүрэхэд биднийг урагш нь хөтлөх нэг томоохон бичиг баримтыг боловсруулахад нэмэр болох ёстой. Энэ бүхэн нь улсын болоод хувийн хэвшлийн хамтын хүчин чармайлтын үр дүн гэдгийг цохож хэлмээр байна. Худалдаа хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр болон Давхар татварын тухай гэрээг боловсруулах үйл явцад Америк, Монголын хувийн хэвшлийнхний аль аль нь оролцсон билээ.

Визний бодлого

Монгол улсын тухайд баримтлах [АНУ-ын](#) визний бодлого ямар байх тухай та нарын олонхи нь асуух байх гэж би таамаглаж байна. Энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг www.travel.state.gov сайтаас авч болно.

Виз: Манай виз олгох бодлого дэлхий даяар адил байдаг. Хэрэв тавигдсан шаардлагыг хангаж байх юм бол Монголчууд 120 сар буюу 10 жилийн хугацаатай В1/В2 визийг авах эрхтэй. Энэ нь цагаачлалын бус зорилгоор виз мэдүүлэгчид олгодог хамгийн дээд хугацаа юм. Виз мэдүүлэгч бүр виз олгогдсон эсэхээс үл хамааран эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр 100 ам.долларын хураамж төлөх бөгөөд консулын ажилтантай нүүр тулсан ярилцлаганд орж, АНУ-д аялах хөтөлбөрийн нэгээхэн хэсэг болох хурууны хээгээ авахуулах шаардлагатай байдаг. Визний ярилцлаганд орох цагийг урьдчилан товлож, нэр бүхий номер тараадаг системийг хэрэгжүүлсэн нь Улаанбаатарт суугаа [АНУ-ын ЭСЯ-нд](#) виз мэдүүлэгчдэд визийн материалаа бүрдүүлэхэд нь

хангалттай хугацаа өгөх зорилготой юм. Одоогийн байдлаар оюутан сурагчид дунджаар 1-2 долоо хоног, бусад цагаачлалын бус виз мэдүүлэгчид 8 долоо хоногийн өмнө визний ярилцлаганд орох өдрөө товлох хэрэгтэй байдаг.

9-р сарын 11-ний үйл явдлын дараа дүрэм журмыг чангатгасан явдал хоёр талын солилцоо, ялангуяа оюутнууд, бизнесийн зорилгоор аялагч нарт хүндрэл учруулж байгаад миний бие болон Төрийн департамент дахь мэргэжил нэгт нөхдүүд маань санаа зовниж байдаг гэдгийг хэлмээр байна. Энэ зөвхөн Монголд хамаатай асуудал биш юм. Бидний бусад сайн найз нөхөд, холбоотнуудад ч мөн энэ асуудал тулгарч байна. Би гомдол саналуудыг ойлгож байна. Бид АНУ-ын аюулгүй байдлыг дээд зэргээр хангахын зэрэгцээ хууль ёсны аялагч, оюутнуудыг дэмжих талаар Конгресс болон Эх орны хамгаалалтын департаменттай хамтран ажиллаж байна.

Улаанбаатарт суугаа ЭСЯ

Яриагаа бага зэргийн рекламаар дуусгахыг минь зөвшөөрнө үү. Монголд суугаа манай ЭСЯ нь Төрийн департамент, Батлан хамгаалах яам, ОУХА болон Энх тайвны корпусын төлөөлөгчдийг багтаасан маш цомхон боловч чадварлаг баг байдаг. Манай ЭСЯ-нд Америкийн байгууллага, компаниудтай хамтран, бас тэднийг төлөөлөн ажилладаг Олон нийттэй харилцах, боловсрол болон солилцооны ажилтан, мөн Худалдааны ажилтан байдаг. Миний хэлэх дуртай байдагчлан манай ЭСЯ-ны "гэр бүл" зөвхөн Америкчууд төдийгүй ажилдаа маш үнэнч нилээд тооны монгол ажилтнуудаас бүрддэг билээ. Хэрэв та бүхэнд ямар нэг төрлийн мэдээлэл хэрэгтэй болвоос бидэнтэй холбоо бариарай. Манай вэб хуудас: www.us-mongolia.com.

Баярлалаа. Амжилт хүсье.